

Монголын орон нутгийн мэдээ

АЗИЙН БҮСИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗАХИАС БИЧИГ

Учир нь зүрх сэтгэлийн дуунд сүнс минь баярлах авай (С ба Г 25:12)

Далын Ахлагч **Жошуа Сабандриё**

Хуучин Гэрээний цаг үеэс эхлэн хамгийн сүүлчийн эрин үе хүртэл Бурханд зориулсан магтаалын дуу нь сайн мэдээний нэг хэсэг байсаар ирсэн билээ. Хуучин Гэрээний судрууд “Бүх дэлхий Их Эзэнд баяртайгаар хашхирагтун: Дуу гарган, баярлан дуулж, магтан дуулагтун” (Дуулал 98:4) хэмээн биднийг урьдаг. Шинэ Гэрээ номонд Паул Колоссайд байгаа гэгээнтнүүдэд “Бурханд хандаж зүрхэндээ баяртайгаар дуулах сүнслэг дуу, магтуу, дуулууд хийгээд бүх мэргэн ухаанаар та нар бие биедээ заан, бие биеэ сэнхрүүлэн Христийн үг та нарын дотор бялхам орших болтугай” (Колоссай 3:16) хэмээн ерөөсөн байдаг.

1830 оны 7-р сард Сүм дөнгөж зохион байгуулагдсанаас хойш 3 сарын дараа Их Эзэн бошиглогч Иосеф Смитээр дамжуулан бошиглогчийн эхнэр Эммад дараах зааврыг өгсөн юм: “Мөн миний сүмд байх, тэрчлэн, намайг баярлуулах сүмийн ариун дуулууд чамд өгөгдсөнчлөн, түүвэр хийх нь чамд өгөгдөх болно. Учир нь зүрх сэтгэлийн дуунд сүнс минь баярлах авай; тийм ээ, зөв шударгыг үйлдэгчдийн дуу нь надад хандсан залбирал бөлгөө, мөн энэ нь тэдний тэргүүн дээр адислалаар хариулагдах болно” (С ба Г 25:11–12). Энэхүү судар бидэнд Дуулууд нь сэргээгдсэн сайн мэдээний нэг хэсэг гэдгийг баталдаг.

Бидний Дууллын номон дээрх Тэргүүн Зөвлөлийн өмнөх үг ийн өгүүлдэг “Урам зориг өгөх дуунууд нь сүмийн цуглаануудын чухал хэсэг юм. Дуулууд нь Их Эзэний Сүнсийг урьдаг төдийгүй хүндэтгэл бишрэлтийн мэдрэмжийг

төрүүлж, гишүүдийн хувьд биднийг нэгтгэж, Их Эзэнд магтаал өргөх боломжийг бидэнд олгодог.

Хамгийн агуу номлолуудын заримыг нь дууллуудыг дуулснаар номлосон байдаг. Дууллууд биднийг наманчлал, сайн ажил хөдөлмөр



Далын Ахлагч **Жошуа Сабандриё**

лүү чиглүүлдэг бөгөөд итгэл, гэрчлэлийг бий болгож, ядарч, зовсон нэгнийг тайтгаруулж, эцсээ хүртэл тэвчихэд бидэнд тусалдаг.

Гэр бүлүүдийг илүү агуу сүнслэг байдал руу хөтөлж, тэднийг сайн мэдээнд өөрсдийгөө зориулахад тусалдаг хязгааргүй их хүч дуунд байдаг. Хожмын Үеийн Гэгээнтнүүд гэр орноо зохистой дуу хөгжмийн аялгуугаар дүүргэх ёстой.

Хүүхдүүддээ дууллуудыг хайрлахыг заа. Тэднээр Хүндэтгэлийн өдөр, гэр бүлийн үдшээр, судар судалж, залбирах үед дуулуул. Ажиллаж, тоглож, аялахдаа тэдэнтэй хамт дуул. Балчир хүүхдүүдийн итгэл, гэрчлэлийг бэхжүүлэх бүүвэйн дуу мэтээр дууллуудыг дуул.

Дууллууд Сүмийн болон гэр бүлийн гишүүд биднийг адислахын сацуу хувь хүмүүсийн хувьд бидэнд агуу ашиг тус болдог. Дууллууд бидний сүнсийг өргөж, бидэнд зоригийг өгч, зөв шударга үйлдэл рүү биднийг хөтөлдөг. Мөн бидний зүрх сэтгэлийг тэнгэрлэг бодлуудаар дүүргэж, сүнсний амар амгаланг авчирдаг.

Дууллууд нь мөн бидэнд дайсны уруу таталтуудыг давж гарахад тусалдаг. . . (Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн дуулал, 1985, хуу. ix-x)

Бид гэрлэснийхээ дараахан Сүмийн дууллуудыг дуулах илүү их хайрыг хөгжүүлж эхэлсэн. Бид хүүхдүүд маань гэртээ ирэх үед оройн залбирлын дараа хамтдаа дууллуудыг дуулах гэр бүлийн уламжлалтай болсон бөгөөд дууллуудыг дуулснаар ирдэг амагдсан адислалыг би хүлээж авсан билээ.

Саяхан бид Зүүн Малайзын Сибу дахь шинэ хөрвөгч гэр бүлийнд зочилсон юм. Хоорондоо танилцсаны дараа бид дуулал дуулахаар шийдлээ. Биднийг дуулахын өмнө гэр бүлийн

эзэгтэй өөрт нь номлогчдын бэлтгэж өгсөн олон хэл дээрх Сүмийн дууллын CD байгаа гэж хэлэв. Тэр гэр бүлийнхээ хамгийн дуртай дууллуудын нэг болох “Гэр оронг маань бидний мөнхөд орших тэнгэр лүү чиглүүлдэг” (Дуулал, 1985, х. 298) дууллыг тавьсан юм. Бид газар суугаад дуулж эхлэв. Биднийг дуулж байхад хайр, эв нэгдлийн сүнс тэрхүү даруухан гэр бүлд ирж байгааг би мэдэрсэн.

Зарахемла дахь Сүмийн шинэ гишүүдэд заасан Алма тэднээс дараах асуултыг асуужээ “. . . Ах дүүс минь, хэрэв та нар зүрх сэтгэлийн өөрчлөлтийг эдэлсэн бол, мөн хэрэв та нар гэтэлгэх хайрын дууг дуулмаар санагдсан бол, би асууя, та нар одоо тийн мэдэрч чадна уу?” (Алма 5:26). Бид Сүм дээр эсвэл гэр бүлдээ эсвэл бүр зүрх сэтгэл дотроо чимээгүйхэн дуулснаар Аврагчийн хайрыг мэдрэх болно. Бидний зүрх сэтгэл рүү алгуурхнаар цутгах Христийн цэвэр хайр бидэнд амар амгалан, тайтгарал болон амьдралын бэрхшээлүүдийг давах урам зоригийг өгөх болно.

Дууллууд мөн суралцах гарын авлага байж болно. Алдартай хүүхдийн дуу болох “Би Бурханы хүүхэд” дуулал нь нас хүйс, боловсрол зэргээс үл хамааран бүх хүнд ойлгомжтой энгийн сайн мэдээдний үндсэн сургаалыг өгүүлдэг. Жанис Капп Перри эгч 2011 оны 9-р сарын 16-нд Сүмийн Түүхийн Музейн лекцийн үеэр Ерөнхийлөгч Бонд К.Пакерийн “Бид дуугаар дамжуулан амархан суралцаж, мэдэрч чаддаг. Хэрэв өөр арга замаар сурах аваас бид маш удаан суралцах болно” хэмээх заавраас эш татсан юм.

Сүмийн дууллууд болон Хүүхдийн дуунуудыг дуулснаар тэнгэрлэг мэдрэмж бидний зүрх сэтгэлд ирдэг гэдгийг би мэднэ. Энэ мэдрэмж нь биднийг Тэнгэрлэг Эцэг, бидний Аврагчид илүү ойртуулдаг бөгөөд “Гэр оронг маань бидний мөнхөд орших тэнгэр лүү чиглүүлдэг” (Дуулал, 1985, х. 298). Есүс Христийн нэрээр, амен. ■

Монгол дахь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Түүхээс

Улаанбаатар Баруун Гадасны түүхч А.Тунгалаг

1993 он. УЛААНБААТАР САЛБАР.

1993.01.03 Нийгмийн Халамжийн бүлгийн Боловсролын зөвлөхөөр Систер Анна М. Харпер, Гэр бүлийн баяжуулалтын зөвлөхөөр Систер Мэри Жэйн Фландро, нарийн бичиг-Систер Донна Бийзли нар дуудагдсан байна.

1993.02.06 Анхны баптисмууд болж, Ахамжавын Пүрэвсүрэн – Ахлагч Стейнли Б.Смит, Цэндхүүгийн Бат-Өлзий – Ахлагч Ричард Г.Харпер нараар баптисм хүртэж, Улаанбаатар салбар нь анхны монгол гишүүдтэй болжээ.

1993.02.14 Фландрогийнхний хүсэлтээр тэдний гэрт Ариун ёслолын цуглаан явагдаж эхэлсэн байна. Ахлагч Фландро өөрийн зочны өрөөг ариун ёслолын танхим адил засч янзалсан нь жинхэнэ цуглааны байр мэт болсон байжээ.

1993.02.19 Тав дахь хос номлогч Ахлагч С.ДюВейн Шмидт, Систер Алис К.Шмидт нар ирж, Ахлагч С.ДюВейн Шмидт Мелкезедик санваартнуудын хэсгийн удирдагчаар дуудагджээ.

1993.02.28 Энэ өдрийн ариун ёслолын цуглаанд Бригам Янгийн Их Сургуулиас ирсэн Лэйн МкЛеннен, Барри Жонсон оролцсон байна. Тэд түр хугацаагаар Англи хэлний сургалт явуулах ажлаар ирсэн бөгөөд салбарын үйл ажиллагаанд туслах мөн Сүмийн дуулалд нэмэлт хүч өгөн дуулах уянгалаг дуу хоолойгоороо гайхалтай байсан ажээ.

1993.03.03 Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлөөс Жон К.Кармак ах болон Кармак эгч нар айлчлан ирж, бүсийн хурал хийжээ. Шинэхэн гишүүд болон сонирхогчдоод Кармак ах эгч хоёроос ариун сүнсийг мэдэрч, тэдний гэрчлэлүүдээр хүчирхэгжих сайхан боломж гарчээ.

1993.04.15 Энэ өдөр Ахлагч Нийл

А.Максвелл “Ариун Төлөөлөгчийн хүч хийгээд эрх мэдлээр сэргээгдсэн сайн мэдээг заахын төлөө Монгол орныг онцгойлон адисласан” юм. Ийнхүү Монгол орон онцгойлон адислагдсан нь монголчуудын хувьд ялангуяа Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн хувьд гайхамшигт өдөр болсон түүхтэй.

1993.04.24 Бригам Янгийн Их Сургуулийн Кеннеди төвийн хөтөлбөрийн дагуу Сүмийн гишүүн Шарлотте Лафгрин мөн түр хугацаагаар Англи хэлний сургалтыг заахаар иржээ.

1993.05.02 Ариун ёслолын цуглаанд 34 хүн ирсний олонх нь өмнөх сарын 26-ны “Өнөөдөр” сонинд Ерөнхийлөгч Бийзлийн өгсөн зарын дагуу ирсэн нь их онцгой тохиолдол болжээ. Ахлагч Фландрогийн гэрийн өрөөнүүд Есүс Христийн сайн мэдээг сурахыг хүссэн зочдоор дүүрсэн нь үнэхээр гайхамшигтай байсан ажээ. Сонирхогчид олноор ирэх болсонд ариун ёслолын цуглаан явуулах илүү том байр олох шаардлага гарч, Ахлагч Бийзли Улаанбаатар зочид буудал, Дүрслэх Урлагийн Их Сургууль болон өөр бусад газруудыг сонирхон судалж эхэлсэн байна.

1993.05.04 Зургаа дахь хос номлогчид болох Ахлагч Гари Карлсон болон Систер Барбара Л. Карлсон нар иржээ. Тэд үйлчлэл хийхээр ирсэндээ, харин салбарыг хөгжүүлэхэд тусламж хэрэгтэй байсан номлогчид тэднийг ирсэнд мөн баяртай байлаа. Тухайн цагт Нийгмийн Халамж болон Хүүхдийн анги мөн Санваартны ангиуд хичээллэж байжээ. Ерөнхийлөгч Бийзли цуглааны шинэ байртай болох үед Сургаалийн удирдамжийн анги нээхийг хүсч байсан тул

Карлсонууд маш таатай нэмэлт хүч болсон аж.

1993.05.08 Даваажаргал/Сильвия/ баптисм хүртэж, анхны эмэгтэй монгол гишүүн болжээ.

1993.05.09 Салбарын анхны үйл ажиллагаа болж, шинэхэн хөрвөгдсөн цөөн тооны гишүүд сонирхогч найз нөхдийн хамт оролцжээ. Салбарын ажил хэрэг, аароны санваартны зөвлөгчөөр Ахлагч Гари Карлсон, аароны санваарын удирдагчаар Ахлагч Жон Нильсон ах, үйл ажиллагааны зөвлөлийн удирдагчаар Систер Алис К.Шмидт дуудагдсан байна.

1993.05.19 Пүрэвсүрэн аароны санваар хүртэж, прист болжээ. Ариун ёслолын цуглаан явуулах шинэ байр хайх эрэл үргэлжилсээр байлаа. Ерөнхийлөгч Бийзли номлогчдын амьдардаг байртай тун ойрхон Энхтайван найрамдлын ордон хэмээх боломжийн байр олж, Ахлагч Смитийн хамт тус Ордоны менежертэй нь байр түрээслэх тухай уулзалт хийхээр тохиролцсон байна.

1993.05.23 Пүрэвсүрэн нь ариун ёслол түгээхэд оролцсон анхны монгол гишүүн болов. Ариун ёслолын углаан дээр ирэх ням гаригийн цуглаан Энхтайван найрамдлын ордоны байранд болохыг зарласан байна. Гэтэл ордны захиргаанаас 6-р сарын 13 хүртэл цуглаанаа хийж болохгүй, улмаар сар бүрийн сүүлийн гурван долоо хоногийн ням гаригуудад л ариун ёслолын цуглаан хийх боломжтой хэмээн мэдэгдсэн гэдэг. Энэ мэдэгдэл сандралд оруулсан боловч Ерөнхийлөгч Бийзлийн чадварлаг зохион байгуулалтаар ариун ёслолын цуглаанаа саадгүй явуулах шинэ байр олж чадсан байна. Энэ нь Улсын төв номын сангийн байранд Сүмийн үйл ажиллагааны зориулалтаар ашиглах танхимууд түрээслэн авсан байжээ.

1993.05.29 Салбарын залуучуудад зориулсан үйл ажиллагаа Ахлагч Шмидтын гэрт болов.

1993.05.30 Энэ өдөр шинэ байранд анхны

Ариун ёслолын цуглаан явагдсан байна. Мөн үргэлжлэн Нийгмийн Халамж, Хүүхдийн анги хичээллэх боломжтой болжээ. Алис К. Шмидт болон Донна Бийзли нар хагас цагаар ээлжлэн, Хүүхдийн ангид зааж, Ахлагч Гари Карлсон Сургаалын зарчмын ангид заах болсон байна.

1993.06.13 Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийн урилгаар ахмад номлогчид Бээжин дэх Салбарын Чуулганд оролцжээ. Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөл Ахлагч Кеннет Х.Бийзлийг Удирдагч ахлагчаар ажиллахыг зааварласан байна. Мөн энэ өдөр Улаанбаатар салбарын ариун ёслолын цуглаанд 20 хүн ирсэн бөгөөд Пүрэвсүрэн ах тэргүүлэн удирджээ.

1993.06.27 Салбарын шинэ Ерөнхийлөгчөөр Ахлагч Ричард Г.Харпер, нэгдүгээр зөвлөхөөр Ахлагч Стейнли Смит, хоёрдугаар зөвлөхөөр Ахлагч Ройс Фландро нар дуудагдсан байна.

1993.07.04 Ариун ёслолыг анх удаа Дикон түгээсэн нь Монголд түр хугацаагаар ирсэн Жон Нильсон ахын хоёр хүүгийн нэг Хөюстон оролцсон байлаа.

1993.07.11 Энэ өдрийн ариун ёслолын цуглаан маш онцгой болсон нь Ази тивээр жуулчилж, мөн наадам үзэхээр монголд ирсэн 35 хүний бүрэлдэхүүнтэй америк аялагчид оролцсон нь цуглааны ирцийг 76 болгожээ. Жуулчдын нэг Ахлагч Ройс П.Фландрогийн эгч дуу дуулж, бэлэг барьсан нь ахмад номлогчдод гэртээ байгаа мэт сэтгэдэл төрүүлсэн гэдэг.

1993.08.01 Ариун ёслолын цуглаан явагдаж, Пүрэвсүрэн Салбарын гүйцэтгэх нарийн бичгээр дуудагджээ.

1993.08.05 “Анхны” гэсэн тодотголтой зүйл дахисан нь Салбарын гишүүн Бат-Өлзийн гэр бүлд анхны хүүхэд нь мэндэлжээ.

1993.08.14 Салбарын хувьд улаанаар бичигдэх бас нэг гайхалтай өдөр тохиосон нь анхны бүрэн цагийн номлогч зургаан залуу Номлогчийг

бэлтгэх төвөөс иржээ. Тэд бол Ахлагч Бретт Эндрыю Хэнсен, Ахлагч Дуэйн Лий Бланчард, Ахлагч Куртис Ди Мортенсен, Ахлагч Жаред К.Майэр, Ахлагч Брадди Жэй Пиерсон болон Ахлагч Барт Жэй Бөрч нар байлаа.

1993.09 сар АНУ-ын Юта Валлигийн Улсын Коллежид монгол оюутнуудыг суралцуулах ажлыг зохион байгуулахаар Коллежийн захирал Малан Р.Жаксон Монгол Улсад иржээ. Ажлын дүнд анхны зургаан оюутантай бүлэг Юта мужид очсон байна. Тэдний нэг нь элчин сайд агсан Нямдоогийн охин Болормаа байлаа.

1993.09.09 Сүмийн орчуулгын орон нутгийн зөвлөл байгуулагдав. Орчуулгын Албаны ажилтан Фелпсын заавраар ариун ёслол болон баптисмын залбирлууд, Сүмийн нэр, Жозеф Смитийн Түүх, номлогчийн ярилцлага хичээлүүд мөн Евангелийн үндсүүд эхлэн орчуулагдахаар төлөвлөгджээ.

1993.09.13 Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийн гишүүн Квок Юн Тай ах гэргий Тай эгчийн хамт ирж Бүсийн хурал хийжээ. Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлд өөрчлөлт орж, Ерөнхийлөгч Монте Ж.Брау дуудлагаасаа чөлөөлөгдөж, эх орондоо буцсан байна. Шинэ Ерөнхийлөгчөөр Ахлагч Жон К.Кармак, түүний Зөвлөхүүдээр Ахлагч Квок Юн Тай /Монгол дахь Салбарыг хариуцах үүрэгтэй/ болон Ахлагч Стивен Ж.Соронсен нар дуудагджээ.

1993.09.23 Улаанбаатар, Сэлбэ салбар зохион байгуулагдав.

1993.09.26 Орчуулгын зөвлөлийн эхний ажил салбарын гишүүн Энхжаргалын орчуулсан Сүмийн нэр монгол хэлээр плакат дээр бэлтгэгдэн гарчээ. Үргэлжлэн Сүмийн ном, бусад материалууд эх хэл дээр хөрвүүлэгдэн байлаа.

1993.10.10 Ариун ёслолын залбирал анх удаа монгол хэл дээр хэлэгдсэн байна.

1993.11.13 Сүм баптисм хүртсэн анхны гэр бүлтэй боллоо. Герман Улсад Баптисм хүртэж,

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн болсон Тогтохын Энхтүвшин ах өөрийн гэр бүлийн гишүүд болох гэргий Дашгэрэл болон таван хүүхдийн /хоёр нь бага насны/ том хүү Тамир, охин Сэлэнгэ, хүү Ананд нартаа баптисм хүртээжээ.

1993.11 сар Улаанбаатар, Сэлбэ салбарын шинээр хөрвөгдсөн гишүүд мөн сонирхогч нарт зориулсан үйл ажиллагааг Үйл ажиллагааны зөвлөлийн удирдагч Жон Нильсон ах, түүний туслах монгол гишүүд амжилттай явуулжээ.

Монголын Парламент “Шашны Шинэ Хууль” баталсан нь хэрэв хэрэгжвэл Сүмийн ажил үйлсэд сөргөөр нөлөөлөх талтай, мөн зарим заалтууд нь хүн бүрт шашны эрх чөлөө олгосон Монголын Шинэ Үндсэн Хуулийг зөрчсөн учир “Шинэ Хуулийг” Дээд Шүүхэд өгч залруулах ажил явагдаж байжээ. Энэ үед Сүмийн Удирдлага Улсын Дээд Шүүхийн шийдвэр гартал болгоомжтойгоор хүлээж байсан ажээ.

1993.12.25 Анх удаа Христийн мэндэлсний баярыг тэмдэглэх боломж монгол гишүүдэд ирж, энэ өдөр 11 хүн баптисм хүртсэн байна.

1993 онд Их Эзэн номлолын ажлыг гайхамшигтай адисласанд, Түүний ажлыг Монголд эхлүүлэх энэхүү ажилд хүчин зүтгэх боломжид номлогчид бүтд маш их талархалтай байлаа. Шинэ онд салбар 52 гишүүнтэй, ариун ёслолын цугааны ирц 100 гаруй хүнтэй, салбарын удирдлага аажмаар санваартан монгол гишүүдэд шилжиж, баптисмын ёслол монгол хэл дээр гүйцэтгэдэг болов. Нийгмийн Халамжийн хичээл мөн монгол хэл дээр заагдаж эхэлжээ.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм Монгол оронд зохих байраа олж тулгамдсан зарим хэрэгцээг нь шийдвэрлэхэд монголчуудад тусалж байлаа. Сүмийн үйл ажиллагааны чухал хэсэг болох хүмүүнлэгийн тусламж нь Монгол Улсын гэр бүлүүдийн сайн

сайхны төлөө үйлчилж эхэлжээ. Барууны коллежийн сурах бичиг, хүн эмнэлэгийн лаборатор-шинжилгээний багаж төхөөрөмжүүд,

эм болон амин дэмийн бэлдмэлүүд мөн бусад хэрэгцээт зүйлсийн дөрвөн тонн ачаа барааг буцалтгүй тусламж болгон нийлүүлжээ. ■

Интернет ашиглан сайн

МЭДЭЭГ ХУВААЛЦАХ НЬ

Н.Пүрэвсүрэн

Сүмийн маань Тэргүүн Зөвлөл болоод Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын удирдагчид өнөөгийн эрс хурдан өөрчлөгдөн, хувирч байгаа техник технологийн шинэчлэлтүүдийг цаг үеийн нөхцөл байдал эрин үеийн шинэчлэлтүүдийн дагуу Есүс Христийн сайн мэдээг бусадтай хуваалцах арга хэрэгсэл болгон ашиглахыг уриалан дуудаж байна. Энэ бол Бурханы хүн төрөлхтөнд өгсөн хожмын үеийн адислал бөгөөд энэ нь Түүний сонгогдсон хүүхдүүдийн эзэмшин, хэрэгжүүлэх бас нэгэн арга хэрэгсэл гэдгийг хэлж байна. Манай сүмийн удирдагчид энэ талаар олон захиасыг бидэнд илгээсэн билээ. Үүний нэг нь Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч М.Расселл Баллард ахын 2007 оны 12-р сарын 15-ны өдөр Хавай дахь Бригам Янгийн Их Сургуулийн оюутнуудад хандан хэлсэн үгс юм. Тэрээр хэлсэн үгэндээ, өнөөдрийн дэлхий маш их өөрчлөгдөж буйг хэлээд

түүний үед сонин, радиогоор мэдээллээ авч, энэ нь тодорхой хугацааг шаарддаг байсан бол одоо ганц товчлуур дараад хэдхэн секундын дотор дэлхийтэй харьцах боломжтой болсныг дурьдав. Тэр мөн өөрсдийгөө гололгүй залуучуудаасаа суралцаж, тэдний дэмийг аван, энэ эрин үеийн техникийг эзэмшихийг ахмад үеэсээ хүсээд, залуучуудыг идэвх санаачлагатай, зөв тэмүүлэлтэй байхыг уриалав.

Азийн Бүсийн Хэвлэл мэдээллийн албаны сургалт Хонг Конг-д болж, азийн нэлээд хэдэн орны вебсайт эрхлэгч, орон нутгийн Лиахона сэтгүүлийн эрхлэгч нар оролцлоо. Уг сургалтанд Солт Лейк хотоос Сүмийн Төв Захиргааны албаны интернет, сүмийн хэвлэл мэдээлэл хариуцсан таван мэргэжилтэн ирж, маш үр өгөөжтэй биечлэн үзүүлбэрийг үзүүлсэн, сургалтыг явууллаа.

Монгол дахь хэвлэл мэдээллийн захирал Ерөнхийлөгч Кларк, вебсайт хариуцсан

Цэрэнням ах болон бусад тухайн албаны гишүүд оролцсон сургалт, семинарыг сар болгон явуулдаг бөгөөд өнгөрсөн 2011 онд Улаанбаатар Баруун гадасны зургаан тойрогт “Интернет ашиглан сайн мэдээг хуваалцах нь” сэдвээр гишүүдэд хандсан яриаг ариун ёслолууд дээр өгч, галын дэргэдэх ярилцлагыг зохион байгуулаа. Уг галын дэргэдэх ярилцлага дээр Цэрэнням ах интернэтээр гишүүдэд сүмийн онлайн хуудаснууд болоод тэдгээрийг зөв ашиглах талаар үзүүлэн нь маш үр дүнтэй боллоо. Цаашид энэ ажил үргэлжлүүлэн явагдах бөгөөд нийт сүмийн гишүүд идэвхтэй оролцож, Есүс Христийн сайн мэдээг гэрээсээ дэлхийн булан бүрт байгаа ах эгч нартайгаа төвөггүй хуваалцана гэдэгт итгэлтэй байна.

Сүмийн гишүүд бид онцгой үүрэг хариуцлагатайгаар энэ үед ирснээ мэднэ. Бид Түүний сайн мэдээг хүн бүрт түгээн, хүргэх үүрэгтэй. Энэ ажилд Бурхан бидэнд шинэ боломж, арга хэрэгслүүдийг бэлтгэж байна. Үүнийг зөв зохистойгоор эзэмшин, Түүний гар дахь бүрэн зэмсэг болцгооё. ■

ГЭГЭЭНТНҮҮДИЙН ДУУ ХООЛОЙ

Дархан-1 ба Дархан-2 салбарын залуус Мормоны Ном ба Есүс Христийн сайн мэдээний талаарх өөрсдийн гэрчлэлийг хуваалцаж байна

Дархан-2 салбарын Ерөнхийлөгч Бямба:

Семинар бол маш чухал зүйл. Залуучууд сургаалыг сонсож, илүү итгэлтэй, дуулгавартай байхад маш их үүрэг гүйцэтгэдэг. Тэд нүдэн дээр өөрчлөгддөг. Манай семинарын багш нар маш гайхамшигтай сайн багш нар. Мөн семинарын хүүхдүүд надад их тусалдаг. Би их азтай хүн, олон сайхан сүмийн гишүүд ах эгч нарын хүчээр олон зүйлийг суралцсан.

Дархан-2 салбарын Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгч, семинарын багш Сувдаа:

Би залуучуудад сайн мэдээг заах болгондоо өөрөө бас суралцаж байдаг. Хүүхдүүдийг семинартаа яваад өөрчлөгдөн, сайн, хөөрхөн болж байгаад маш их баярладаг. Бурханы сургаалыг суралцаж, илүү зорилготой болсондоо мөн маш их баярладаг. Гэр бүлээрээ ариун сүм яваад ирсэн, маш их сайхан байлаа. Өглөө семинарын хүүхдүүдээ утсаар сэрээдэг. Өглөө эрт элдэв салхи шуурга, хүйтэн, цас, бороонд алзахгүй семинартаа явдагт нь би хүүхдүүдээрээ маш их бахархдаг.

Дархан-2 салбарын гишүүн Баасан-Очир,

17 нас: Би Одгэрэл ахын заасан сургаалаас маш их зүйл сурч, тэр тосыг дүүргэх зүйлийг үзүүлсэн нь надад их зүйлийг бодогдуулсан. Бурханы үгсээр байж, бувтнахгүй байснаар сайн сайханд хүрнэ гэдгээ би мэддэг.

Дархан-2 салбарын гишүүн Мандухай: 2011 онд анх удаагаа залуучуудын чуулганд оролцож, тэвчээртэй байхыг маш сайн сурсан. Би

тэвчээр муутай. Мөн ялан дийлэгч байхын тулд ямагт залбирал гэдгийг үнэхээр зүрх сэтгэлээсээ ойлгож, сурсан. Бурханы охин байна гэдэг агуу зүйл юм.

Дархан-2 салбарын гишүүн Энхномин,

17 нас: Залуучуудын чуулган үнэхээр гайхамшигтай. Би тав дахь жилдээ оролцож байгаа, сүмийн гишүүн болоод ес дэх жилдээ орж байна. Сүмийн гишүүн байх маш сайхан, олон жил болсон ч сурах зүйлс ундарсаар л байдаг. Сургаалаар амьдрах тусам амжилт асар ихээр ирдэг, тийм учраас би олон олимпиадуудад түрүүлж байсан.

Дархан-2 салбарын гишүүн Бямбацэцэг,

16 нас: Сүмийн гишүүн болоод 2 дахь жилдээ болж байна. Багш нарынхаа хичээлээс асар их зүйлийг, дуулгавартай байх, наманчлах мөн бувтнахгүй байхыг сурсан.

Дархан-2 салбарын гишүүн Отгондулам:

Би сүмд ороод 10 жил болж байна. Энэ сүмд явснаар хүмүүс маш их адислалыг хүртдэг, энэ бол үнэн.

Дархан-2 салбарын гишүүн Оюун-Эрдэнэ,

15 нас: Би семинарын хичээлээс хүмүүстэй эелдэг харьцахыг, наманчлахыг сурсан. Манай сүмийн гишүүд бусад хүүхдүүдээс үнэхээр ялгаатай байдаг. Тэд их эелдэг мөн найрсаг. Мөн би Дархан-2 салбарынхаа гишүүдэд маш их талархаж явдаг.

Дархан-2 салбарын гишүүн Пүрэвцогт,
16 нас: Би залуучуудын чуулгандаа оролцох их дуртай. Учир нь багш нарын заасан хичээл маш гоё байдаг. Бас олон найз нөхөдтэй болдог.

Дархан-1 салбарын гишүүн Нуржсан,
17 нас: Би сүмийн гишүүн болоод таван жил болж байгаа Семинарт явснаар өөрсдийнхөө муу талыг хаяж, сайжирч чадсан юм болов уу гэж би боддог. Мөн семинар маань залуучуудыг улам ойр дотно байж хүчирхэг найрамдалтай, найз нөхөд болгож, бие биендээ туслахад нь урамшуулсан гэж би боддог. Би үнэхээр Бурхан байдаг гэдгийг зүрх сэтгэлээрээ мэдэрсэн.

Дархан-1 салбарын гишүүн Өнөрболд,
16 нас: Есүс Христ биднийг Ариун сүнсээрээ дамжуулан биднийг хамгаалдаг гэдгийг би сурсан. Нэг өглөө би эрт босоод семинартаа явж байтал, манай айлын зуудаг нохой миний урд зогсож байсан. Би Тэнгэрлэг Эцэгтээ залбираад хажуугаар нь гарахыг хичээсэн. Гэтэл тэр над уруу арирсан. Мормоны Номоо урдаа бариад, “би мормон хүн намайг зүгээр орхи тэгэхгүй бол чамд муу зүйл болно шүү” гэж хэлтэл тэр нохой миний хажуугаар юу ч болоогүй юм шиг өнгөрөөд яваад өгсөн. Тэгэхэд би Тэнгэрлэг Эцэг намайг харж ханддагийг мэдсэн.

Дархан-1 салбарын гишүүн Чинбат,
16 нас: Би сүмийн гишүүн болоод нэг жил болж байна. Залуучуудын чуулганд анх удаагаа 2011 онд явж, маш их зүйлийг сурсан.

Бас олон найз нөхөдтэй болсон. Семинартаа явахгүй нэг өдөр болохоор тэр өдөр маш эвгүй бүтэлгүй байдаг. Би семинартаа явах маш их дуртай.

Дархан-1 салбарын гишүүн Сумъяахүүхэн,
17 нас: Бид Мормоны Ном болоод бошиглогчдын үгсээс их зүйл суралцаж чаддаг. Би Мормоны Номондоо хайртай.

Дархан дүүргийн Дээд Зөвлөлийн гишүүн Чулуунбаатар: Би Америкийн Небраска мужид номлолд үйлчилсэн. Эхнэр 2 хүүхэдтэй. Манай сүм цорын ганц үнэний сүм бөгөөд Христийн сайн мэдээ үнэхээр хүмүүсийн амьдралыг өөрчилдөг гэдгийг би мэднэ. Сүмдээ явснаар бид сайн сайхныг олдог. Би залуучуудтайгаа ажиллах дуртай, тэд миний гэрчлэлийг улам хурцалж байдаг.

Дархан-1 салбарын семинарын багш Бадамдулам: Би семинар зааснаараа хүүхдүүдээсээ маш их зүйлийг сурч, их өсөж хөгжсөн. Намайг хүмүүс хараад хорин хэдэн хүүхдийн ээж явж байна гэдэг. Манайд 2011 онд 30 хүүхэд семинарт хамрагдаад, 23 хүүхэд семинарын ангийг төгсгөсөн. Би мөн салбарын маань семинарын анги бүх зүйлээрээ тэргүүлж байгаад маш их баяртай байгаа. Энэ бол хүүхдүүдийн маань идэвх, итгэл юм.

Дархан-2 салбарын гишүүн Мөнхбаясгалан,
15 нас: Залуучуудын чуулган гайхалтай. Тэнд заасан хичээлүүд дотроос Абрахамын тухай хичээлээс бид өмнөх дэлхийд сонгогдсон байсан гэдгийг сурсан. ■